

5

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ХАНДЛАГА

Б.Алтанцэцэг


Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд 15 жилийн нүүр үзэж байна. Шилжилтийн жилүүдийн эдийн засгийн уналтын үед засгийн газар Олон улсын валютын сангийн санал болгодог “цочроох эмчилгээ” хэмээгдэх тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлсэн.

1. Эдийн засгийн өсөлт

Шилжилтийн эхний жилүүдэд эдийн засаг эрс уналтанд орж, 1990-1993 оны хооронд ДНБ 20 гаруй хувиар буурсан. Харин 1994 оноос хойш буюу сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд эдийн засаг эерэг өсөлттэй байна. Хэдий тийм боловч эдийн засгийн өсөлтийн хурд тогтворгүй, ихээхэн хэлбэлзэлтэй байгааг зураг 1-ээс харж болно.

Зураг 1. ДНБ-ний өсөлтийн хурд

ДНБ-ний өсөлтийн хурд, 1981-2003 (%)



Эдийн засгийн өсөлтийн дундаж хурдыг хүснэгт 1-д харуулж байна. 1980-1989 онд эдийн засаг дунджаар 8.1 хувийн өсөлттэй байсан бол 1994-2003 онд дунджаар 3.5 хувь байна.


Хүснэгт 1. Дундаж болон нийт өсөлтийн хурд.

	1980-1989	1990-1993	1993-2002
Дундаж өсөлтийн хурд	8.1	-5.6	3.5
Нийт өсөлтийн хурд	73.2	-22.3	31.3

Эдийн засгийн өсөлтийн хурдны өчүүхэн бага ялгаа ч урт хугацаанд ялгаатай байдал үүсгэх магадлалтай. Сүүлийн 10 гаруй жилийн эдийн засгийн өсөлтийн үр дүнд ДНБ 1989 оны түвшиндээ 2002 онд буюу 13 жилийн дараа л хүрсэн байна. 2003 оны байдлаар манай эдийн засгийн үйлдвэрлэл 1989 онд байсан түвшнээсээ ердөө 7.9 хувиар л илүү байна.


Зураг 2. Бодит ДНБ.

Бодит ДНБ, (тэрбум төгрөг)



Нэг хүнд оногдох ДНБ нь хүмүүсийн амьжиргааны түвшинтэй шууд холбоотой, түүнийг төлөөлөх үзүүлэлт билээ. Зураг 3-т хүн ам ба нэг хүнд оногдох ДНБ-ний өсөлтийн хурдыг харуулсан байна.

Зураг 3. Нэг хүнд оногдох ДНБ-ний өсөлтийн хурд.



Шилжилтийн эхний үе болох 1990-1993 онд нэг хүнд оногдох ДНБ эрс унасан бөгөөд түүнээс хойш өсөлт нь тогтвортой бус байна. Тухайлбал, 2000, 2001 онд өсөлтийн хурд нь харгалзан -0.3, -0.4 хувь байсан. Харин 2002 онд өсөлт нь эерэг болж, 2.5 хувьд хүрсэн. 2002 оны байдлаар нэг хүнд оногдох бодит ДНБ 268.0 төгрөг бөгөөд 1989 оны түвшнээс 15.8 хувиар доогуур байна. Өөрөөр хэлбэл, монголчуудын амьжиргаа 13 жилийн өмнөх түвшиндээ одоо хүртэл хүрч чадаагүй л явж байна. Улс орнуудын хүний хөгжлийн түвшнийг хэмждэг хүний хөгжлийн индексийн (ХХИ) үзүүлэлтийг тооцоход нэг хүнд оногдох ДНБ ордог. Манай улс 2003 оны “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-д ХХИ-ээр нь жагсаахад 175 улсаас 117 дугаар байранд орсон байна. Гэтэл ХХИ-ийн үзүүлэлтийг ихээхэн доош татаж буй үзүүлэлт нь нэг хүнд оногдох ДНБ юм.

Зураг 4. Нэг хүнд оногдох бодит ДНБ.



Нэг хүнд оногдох ДНБ нь хот хөдөөд ихээхэн ялгаатай байна гэж “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-д тэмдэглэжээ.¹ Хотын нэг хүнд оногдох ДНБ² хөдөөгийнхөөс 2.8 дахин их байна. 2002 оны хотын нэг хүнд оногдох ДНБ 1999 оны түвшнээсээ 38.0 хувиар өссөн байхад, хөдөөгийн нэг хүнд оногдох ДНБ-д бараг өөрчлөлт гарсангүй. Эндээс үзвэл, хот хөдөөгийн амьжиргааны түвшин улам бүр ялгаатай болж байна.


¹ Энэхүү мэдээллийг “Монголын хүний хөгжлийн илтгэл 2003”-аас авсан.

² Нэг хүнд оногдох ДНБ нь PPP ам.доллараар илэрхийлэгдсэн.

2. Салбарын үйлдвэрлэл

ДНБ-ний салбарын бүтцийг сүүлийн 6 жилээр авч үзье. 1999 он хүртэл, ХАА нь манай эдийн засгийн хамгийн том салбар байсан бөгөөд ДНБ-ний 40 хувьтай тэнцүү байжээ.


ХАА, ой, ан агнуурын салбарын өсөлтийн хурд, (%)



Харин сүүлийн 3 жилийн дотор ХАА-н үйлдвэрлэл эрс буурч ДНБ-ний 23.6 хувьд хүрэн, эдийн засгийн 3 дах том салбар болсон.

Энэ хугацаанд бусад бүх салбарын эзлэх хувь өссөн байна. Ялангуяа, худалдаа, тээвэр, холбооны салбаруудын эзлэх хувь эрс өссөн. Сүүлийн 6 жилийн хугацаанд тээвэр, холбооны салбарын эзлэх хувь 70.0 хувиар өсч, ДНБ-ний 11.9 хувийг эзлэх болсон.

ДНБ-ний бүтэц гол салбаруудаар, (%)




	1997	1998	1999	2000	2001	2002
■ үйлчилгээ	11.1	10.9	11.2	11.3	11.2	11.5
■ Худалдаа	18.8	17.6	17.2	21.5	23.3	25.2
□ Тээвэр, холбоо	7	7.3	7.5	9.3	10.6	11.9
□ Барилга	1.6	1.5	1.5	1.3	1.4	1.5
■ ХАА	38.9	39.9	40.3	34	27.4	23.6
■ Аж үйлдвэр	22.6	22.7	22.3	22.6	26.1	26.3


3. “Эс аж үйлдвэржих” үзэгдэл

Шилжилтийн үеийн бас нэг сонирхолтой үзэгдэл бол “эс аж үйлдвэржилт” деиндустриализацийн үзэгдэл юм. 1990-1999 оны хооронд эс аж үйлдвэржилт буюу аж үйлдвэргүйжилт явагдсан байна. 1990 онд аж үйлдвэрийн салбар ДНБ-

ний 33.2 хувийг эзэлдэг хамгийн том салбар байсан. Харин ХАА нь 30.7 хувь эзэлдэг хоёрдох том салбар байжээ.



Мөн хугацаанд ДНБ-ний салбарын бүтэц эрс өөрчлөгдсөн бөгөөд ХАА-н салбарын эзлэх хувь 30.0 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 30.0 хувиар буурсан. 1999 онд ХАА нь ДНБ-ний 40.3 хувийг эзэлдэг хамгийн том салбар болсон байхад аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 22.3 болж хоёрдугаар байранд орсон



Ийм эрс өөрчлөлт гарахад малын болон аж ахуйн нэгжийн хувьчлал зонхилох нөлөө үзүүлсэн. Монгол Улсад өмч хувьчлал 1991 онд Засгийн газрын тогтоолоор Төрийн өмчийн хороо байгуулагдснаар эхэлсэн юм. Мал хувьчлал нь хүмүүст орлогоо нэмэгдүүлэх боломжийг олгосон бол аж ахуйн нэгжийн хувьчлал нь цомхтгол, ажилгүйдлийн үр дагаврыг бий болгосон.

“Өмч хувьчлалын ядуурал, тэгш бус байдалд үзүүлсэн нөлөө” сэдэвт судалгаанд хамрагдсан хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн 50.8 хувь нь хувьчлалын дараа цомхтгол хийсэн гэж хариулжээ. Түүнчлэн, 25.6 хувь нь хувьчлалын дараа үйл ажиллагаа явуулаагүй байна. Иймд хотын хүн ам өөрийн амьжиргаагаа дээшлүүлэхээр хөдөөг зорьж байжээ.



Мал хувьчлалын үед хувьдаа малтай өрхийн тоо 7.7 хувиар өссөн бөгөөд харин дараа нь аажмаар цөөрч байжээ. Харин 2000-2002 оны зуднаар малтай өрхийн тоо эрс цөөрсөн.

4. Тогтворжуулах бодлого

Шилжилтийн үеийн эдийн засгийн хямралыг даван туулахад хэрэгжүүлсэн гол бодлого нь Олон улсын валютын сангийн санал болгодог “цочроох эмчилгээ” нэртэй тогтворжуулах бодлого юм. Энэхүү тогтворжуулах бодлого нь нийт эрэлтийг бууруулахад чиглэгддэг. Тухайлбал, бодит цалин, орлогын бууралтыг үл харгалзан цалин, тэтгэвэр тэтгэмжийг царцаах бодлого баримталдаг. Сүүлийн үед монголын эдийн засагт тогтворжуулах бодлогын үзүүлсэн нөлөөллийн талаар олон улсын эрдэмтэд өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний ажил хийсэн бөгөөд “цочроох эмчилгээ” эдийн засагт ихээхэн сөрөг үр дагавруудыг авч ирсэн гэж дүгнэж байна.³ Тухайлбал, орлогын лгаатай байдал ихсэж, амьжиргааны түвшин буурч, ядуурал ихэссэн гэж үзжээ.

³ НҮБХХ-ийн санхүүжүүлж, К. Гриффиний удирдсан судалгааны багийн дүгнэлт.